



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.29-т "Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох"-оор, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 4-т "Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах"-аар тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 47 дугаар тогтоолоор "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого" батлагдсан бөгөөд уг бодлогын баримт бичгийн 3.2.1-д Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн тогтолцоо, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох замаар салбарын хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд "Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн актыг боловсронгуй болгож, Монгол Улсын хууль болон олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ." гэж заасан.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Их Хурал 1995 онд Харилцаа холбооны тухай хуулийг анх удаа батлан гаргаж байсан бөгөөд үүний дараа 2001 онд Харилцаа холбооны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан мөрдүүлсэн нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэ хугацаанд тус хуулинд 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Харилцаа холбооны тухай хуулиар харилцаа холбооны зах зээл дэх төрийн оролцоог багасгах, салбарын зах зээлийг либеральчлах зорилгоор зохицуулалтыг бүрдүүлсэн бөгөөд энэ нь зохих үр дүнгээ өгсөн. Өнгөрсөн хугацаанд хуулиар зохицуулж байсан зах зээлийн харилцаа болон техник, технологид зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд гарч, Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан тоон дамжуулах сүлжээ, суурин болон үүрэн холбооны сүлжээ, олон сувгийг

дамжуулах сансрын хиймэл дагуулын сүлжээг байгуулсан. Эдгээр сүлжээг ашиглан яриа, интернэт, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг хүргэж байна.

Үүний үр дүнд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн бүх салбар, иргэдийн амьдралд мэдээлэл, харилцаа холбооны салбарын дэвшилтээ технологи, үйлчилгээ, хэрэглээ нэвтэрч, өдөр тутмын хэрэгцээ, шаардлага, үйл ажиллагааных нь салшгүй хэсэг болсон. Түүнчлэн харилцаа холбоо, мэдээллийн технологи нь тоон эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүчин зүйл болж байна. Иймд харилцаа холбоо, мэдээллийн технологийн цаашдын хөгжил, зах зээлийн үр өгөөжтэй, шударга өрсөлдөөнийг дэмжсэн, иргэн, хуулийн этгээдийг харилцаа холбоо, мэдээллийн технологийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хүртээмжтэй хангахад чиглэсэн дараах хэрэгцээ, шаардлагын хүрээнд хуулийн зохицуулалт шаардлагатай болоод байна. Үүнд:

1.Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хурдацтай хөгжил, зах зээл, өрсөлдөөний орчны өөрчлөлт, шинэчлэлтийн чиг хандлагад нийцүүлэн салбарын бодлого, зохицуулалтыг оновчтой болгож, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийг тодорхой болгож, зааглах.

2.Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгджэх эхэлсэнтэй холбоотой тус салбарын хэм хэмжээ тогтоосон актыг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих байгууллагуудыг тодорхой болгох шаардлагатай байна. Жишээ нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос батлан мөрдүүлж байсан 70 гаруй захиргааны актаас хуулиар тусгайлан эрх олгоогүй улмаас 50 гаруй нь нийтээр дагаж мөрдөгдөх боломжгүй болж салбарт техникийн зохицуулалт хийхэд хүндрэл үүсээд байна.

3.Техник, технологийн хурдацтай хөгжил, дэвшил нь эргээд техник, технологи хоорондын нэгдэн нийлэлтийг бий болгож байгаа бөгөөд энэ нь нийгэм, эдийн засгийн салбар, бизнест төдийгүй хэрэглээний түвшинд, цаашлаад өрсөлдөөний зохицуулалтад шинэ чиг хандлагыг бий болгож байна.

Харилцаа холбооны зах зээлийн өрсөлдөөнтэй холбоотой асуудлаар иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллаж байгаа хэдий ч Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан 2017 оны тоон мэдээг авч үзэхэд салбарын хэмжээнд нийт 208 гомдол ирүүлсний 89 хувь нь буюу 185 гомдол нь хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдсөн, өрсөлдөөн хязгаарлах үйлдэл гарсан талаархи гомдол, санал байгаа нь тус салбарт өрсөлдөөн, үйлчилгээний үнэ тарифын чиглэлээр хараат бус, бие даасан зохицуулалт хийхэд одоогийн хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа эрх зүйн зохицуулалт шаардлага хангахгүй байгааг илтгэж байна.

Иймд салбарын зах зээлийн өрсөлдөөн, үйлчилгээний үнэ тарифыг зохицуулахтай холбоотой зохицуулах байгууллагын чиг үүргийг нэмэгдүүлж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн үйлчилгээ тус бүрээр зах зээлийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүн, өөрчлөлтийг үндэслэн тухайн зах зээл дэх зүй ёсны монополь, давамгай байдалтай болон зах зээлд нөлөө үзүүлэх хүч бүхий

үйлчлэгч, монополь шинжтэй үйлчилгээг тодорхойлох, зохицуулах, хэрэгжилтийг хангуулах, үр дүнг үнэлэх, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагааг хориглох, хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалт бий болгох шаардлагатай байна.

3. Салбар бүрд мэдээлэл, харилцаа холбооны технологи, үйлчилгээ нь харилцан уялдаагүй, нэгдсэн бодлогогүй, асар их хэмжээний хөрөнгө оруулалтын давхардалтайгаар нэвтэрч байна.

Жишээлбэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 онд хийсэн судалгаагаар төрийн захиргааны 10 байгууллага дээр мэдээлийн технологийн чиглэлээр гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих болон хэрэгжиж байгаа төслүүдийг авч үзэхэд 200 гаруй сая ам.долларын төсөвт өртөг бүхий 17 төсөл арга хэмжээ байгаагаас 9 төслийн явц удаашралтай, зээлийн ашиглалтын хувь бага байна. Энэ нь улс орны хэмжээнд мэдээллийн технологийн төслийн нэгдсэн удирдлага байхгүй, энэ чиглэлээр байгууллага хоорондын ажлын уялдаа сул, улс орны өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд төслүүдийг чиглүүлэх чиг үүрэг орхигдсонтой холбоотой байна.

Иймд Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологийг нэгдмэл бодлого, төлөвлөлт, зохион байгуулалттай хөгжүүлэхийн тулд харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь салбар хоорондын уялдааг хангах хуулийн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

4. Монгол Улсад мэдээллийн технологи эрчимтэй хөгжиж, аливаа байгууллагын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг, үйлчилгээний чухал хэрэгсэл болж байгаа хэдий ч мэдээллийн технологийн ашиглалт, хэрэглээтэй холбоотой эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна. Нөгөө талаар, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, шийдлийг авч ашиглах нь хөрөнгө оруулалт ихээр шаардахын зэрэгцээ нэвтрүүлсэн технологи, худалдаж авсан систем нь байгууллагын үйл ажиллагааг бүрэн дэмжин, стратегийн зорилт, чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэхэд аливаа байгууллага бүрэн итгэлтэй байх эрэлт хэрэгцээ үүсээд байна.

Мөн мэдээллийн технологийн салбарын хэмжээнд зохион байгуулагддаг "GOVTECH-2017" чуулган, "GOVSEC-2017", "Мэдээллийн технологийн аудитын тогтолцоо, эрх зүйн орчинг бий болгох нь" сэдэвт семинар зэрэг томоохон арга хэмжээнүүдээс гаргасан зөвлөмжүүдэд "Харилцаа холбооны тухай хуульд мэдээллийн технологийн аудитын талаар холбогдох заалтуудыг оруулах", "Төрийн байгууллагууд дотооддоо ашиглагдах мэдээллийн системийг хүлээж авах, ашиглахдаа аудит хийлгээдэг байх зохицуулалттай бий болгох бий болгох", "хувь хүний өгөгдөл, мэдээлэлтэй харьцдаг бол тухайн байгууллага хувь хүн мэдээллийн технологийн аудит тогтмол хийлгээдэг байх" талаар тусгагдсан байдаг.

Эдгээр эрэлт, хэрэгцээг мэдээллийн технологийн аудитын үйлчилгээгээр хангадаг боловч манай улсад энэ чиглэлийн харилцааны эрх зүйн орчин бүрэлдээгүй байна.

5."Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын 2.3.4-д "мэдээлэл, харилцаа холбооны судалгаа-хөгжлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, шинжлэх ухаан технологийн парк байгуулах арга хэмжээ авч Монгол Улсад инноваци, судалгаа-хөгжлийн нэгдсэн тогтолцоо бий болгоно" гэж заасан байдаг.

Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх үүднээс мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг явуулах, судалгааны үр дүнг бодлого, зохицуулалт, шинэ технологи хөгжүүлэх, үйлдвэрлэл, инновацийн үйл ажиллагаатай холбосон хуулийн зохицуулалтын орчин бүрдүүлэх шаардлага байна.

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайланд эдгээр асуудлыг шийдвэрлэх шаардлагатайг зөвлөсөн юм.

Иймд дээр дурдсан хууль зүйн үндэслэл болон практик хэрэгцээ, шаардлагуудыг үндэслэн Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэ хуулийн төсөл нь төрийн бодлого, зохицуулалтын чиг үүргийн ялгаа, заагийг илүү тодорхой болгох, салбарын үр ашигтай, шударга өрсөлдөөнийг дэмжих бодлого, зохицуулалтыг хөгжлийн шинэ шатны зорилго, зорилтуудад нийцүүлэн сайжруулах, салбар бүрд мэдээлэл, харилцаа холбооны хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа үед төрийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалт, уялдааг хангах, цахим засаг ба үйлчилгээний удирдлага, тогтолцооны хуулийн зохицуулалт, тоон эдийн засгийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилготой.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасны дагуу хуульд өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгуурлан зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараахь байдлаар тусгана. Үүнд:

1.Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хурдацтай хөгжил, зах зээл, өрсөлдөөний орчны өөрчлөлт, шинэчлэлтийн чиг хандлагад нийцүүлэн салбарын бодлого, зохицуулалтыг оновчтой болгож, холбогдох байгууллагын чиг үүргийг тодруулж, эрх зүйн зохицуулалтгүй байдлаас үүсдэг маргаантай асуудлыг шийдвэрлэнэ. Энэ хүрээнд:

-харилцаа холбоо, мэдээллийн технологи, радио телевиз, контент, шуудан, сансрын технологийн хөгжлийн асуудлаар шинэ технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл, төлөвлөлт, салбар дахь өрсөлдөөний болон бүх нийтийн үүргийн талаархи бодлогыг боловсруулж, батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах зохицуулалтыг тусгана.

-үндсэн сүлжээний тогтвортой ажиллагааг хангах, хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх техник, технологи, зохион байгуулалттай холбогдох харилцааг боловсронгуй болгоно.

-харилцаа холбооны талаархи баримтлах бодлого, хууль, дүрэм, журам, эрх зүйн актын талаар санал боловсруулах, мэдээллээр хангах зохицуулалтыг нэмж тусгана.

-харилцаа холбоо, мэдээллийн технологи, радио телевиз, контент, цахим гарын үсэг, домэйн нэр болон шуудангийн асуудлаар батлагдсан бодлогын хүрээнд зохицуулалт хийхтэй холбоотой нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт батлах, хэрэгжилтийг хангуулах зохицуулалтыг тусгана.

-үйлчилгээний болон харилцан холболт, холболтын үнэ тариф, радио давтамж, домэйн нэр, дугаарлалтын талаархи болон өрсөлдөөн, зах зээлийн багтаамжийг тодорхойлох, зохицуулалт хийх, хэрэгжилтийг хангуулах талаар зохицуулалтыг нэмж тусгана.

-техникийн болон үйлчилгээний чанар, норм, нормитивыг тогтоох, батлах, хэрэгжүүлэх, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хийх, техник, технологитой холбоотой олон нийтийн эрх ашиг хөндөгдөж буй асуудалд зохицуулалт хийх, хэрэгжилтийг хангуулна.

-зохицуулалтын чиглэлээр салбар хоорондын зөвшилцөл, хамтын ажиллагааг бий болгоно.

2.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн үйлчилгээ тус бүрээр зах зээлийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэслэн тухайн зах зээл дэх зүй ёсны монополь, давамгай байдалтай болон зах зээлд нөлөө үзүүлэх хүч бүхий үйлчлэгч, монополь шинжтэй үйлчилгээг тодорхойлох, зохицуулах, хэрэгжилтийг хангуулах, үр дүнг үнэлэх, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагааг хориглох, хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалт бий болгоно.

3.Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологийг нэгдмэл бодлого, төлөвлөлт, зохион байгуулалттай хөгжүүлэх, салбар бүрд мэдээлэл, харилцаа холбооны технологи харилцан уялдаагүй, нэгдсэн стандартгүй, хөрөнгө оруулалтын давхардлыг үүсгэн нэвтэрч байгааг өөрчилж, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь салбар хоорондын уялдааг хангах хуулийн зохицуулалтыг бий болгоно.

4.Харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдээллийн технологийн талаархи эрх, үүргийг тодорхой болгоно.

5.Мэдээлэл, харилцаа холбооны салбарын өрсөлдөх чадвар, үр ашиг, аюулгүй байдал, чадавхыг дээшлүүлэх, нийгэм, эдийн засгийн бусад салбарт шинэ үйлчилгээ, хэрэглээг нэвтрүүлэхэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитын тогтолцоог бий болгох зохицуулалтыг тусгана.

6.Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг явуулах, судалгааны үр дүнг бодлого, зохицуулалт, шинэ технологи хөгжүүлэх, үйлдвэрлэл, инновацийн үйл ажиллагаатай холбосон хуулийн зохицуулалтыг тусгана.

7.Монгол Улс олон улсын гэрээнд заасан нэр томьёотой холбоотой өөрчлөлтийг нэмж тусган, хуулийн зарим нэр томьёог өөрчлөн шинэчилнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдснаар эдийн засаг, нийгмийн дараахь үр дагавар бий болно гэж үзэж байна. Үүнд:

1.Тоон эдийн засгийг хөгжүүлэх, НҮБ-ын чуулганаас баталсан “Тогтвортой хөгжлийн 2030 оны зорилтууд”-ыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж, нийгэм, эдийн засгийн бүх салбарт зерэг нөлөө үзүүлнэ.

2.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр төрийн бодлого, зорилтыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар ханган хэрэгжүүлэх боломж бүрдэж, Монгол Улсын салбар хоорондын харилцаа холбоо, мэдээллийн технологийн бодлого, төлөвлөлтийн нэгдмэл байдлыг хангаж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн давуу талыг ашигласны үр дүн нэмэгдэн, давхар хөрөнгө оруулалт эрс буурч, үйлчилгээний чанар сайжирна.

3.Салбарын судалгаа шинжилгээний үйл ажиллагааг боловсронгуй болгосноор харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг бүх нийтийн хүртээл болгох, өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, мэдлэгт сууринсан эдийн засгийн хөгжлийг хурдаасгах боломж бүрдэнэ.

4.Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх, үүргийг оновчтой, тодорхой болгож, оюуны өмч, өрсөлдөөн, мэргэжлийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой салбарын зохицуулалтын хийдэл, давхардлыг арилгана.

5.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитын тогтолцоо, эрх зүйн орчныг бий болгосноор байгууллагын болон байгууллага хоорондын дэд бүтэц, сүлжээ, мэдээллийн систем, мэдээллийн сан нь тухайн байгууллагын зорилго, зорилт, стандарттай нийцэж, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны бүтээмж, үр ашиг, чадавх, өрсөлдөх чадвар нэмэгдэж, харилцаа холбоо, мэдээллийн аюулгүй байдал, чанар, найдвартай ажиллагааны түвшин дээшилнэ.

6.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг бүх нийтийн хүртээл болгож, хүний хөгжлийн чадавхыг дэмжиж, амьдралын чанарыг дээшлүүлж, хувь хүний өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

7. Монгол Улсын олон улсын гэрээнд тусгагдсан нэр томьёог дотоодын эрх зүйн баримт бичигт тусгаснаар харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хэрэглэгдэж байгаа нэр томьёог нэгдмэл байдлаар буюу нэг мөр ойлгох нөхцөл бүрдэнэ.

8. Хуулийн зарим зүйл, заалтын давхардал, хийдэл, зөрчил арилна.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

Энэ хуулийн төсөлтэй холбогдуулан шаардлагатай бол холбогдох хуульд өөрчлөлт оруулна.

-ооОоо-